


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 19 өдөр

дугаар А/59

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх серөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжүүлэх полимеразын гинжин урвал /ПГУ/-ын шинжилгээнд иргэдийг хамруулах түр журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Наранзул/-д, Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл /Б.Дармаа/-д тус тус даалгасугай.
4. Шаардлага хангасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжилт олгохыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянтогтох/, Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

С.ЭНХБОЛД


С. Энхболд

Эрүүл мэндийн сайдын 2021 оны... дугаар
сарын 19 өдрийн 9/59 дугаар тушаалын
хавсралт

**Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжүүлэх полимеразын
гинжин урвал /ПГУ/ шинжилгээнд даатгуулагчийг хамруулах түр журам**

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авч буй болон тархвар судлалын заалтаар шинжилгээнд хамрагдаж байгаа даатгуулагчдад Коронавируст халдварт (КОВИД-19)-ын шинжилгээг полимеразын гинжин урвал /ПГУ/-аар шинжлэхтэй холбоотой харилцаа энэхүү журмаар зохицуулагдана.

1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон даатгуулагч нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.2 дахь заалт, 13 дугаар зүйлд заасан үүргийг хүлээнэ.

1.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай гэрээ байгуулсан байх бөгөөд шалгуур хангасан эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийг олгоно.

1.4. Коронавируст халдварт (КОВИД-19) голомтлон гарсан бүс нутагт эмчийн заалтаар хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай болон тархвар судлалын заалтаар шинжилгээнд хамрагдаж буй даатгуулагчийн коронавируст халдварт (КОВИД-19)-ын полимеразын гинжин урвал /ПГУ/-ын шинжилгээний сард 3-4 удаагийн зардлыг Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжүүлнэ.

1.5. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт судалгааны алба, өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч болон эрүүл мэндийн байгууллагын тархвар судлаач эмч коронавируст халдварт (КОВИД-19)-ын нэгдсэн мэдээллийн санд даатгуулагчийн мэдээллийг (регистрийн дугаар) бүртгүүлнэ.

1.6. Төрөөс полимеразын гинжин урвал /ПГУ/ болон РНХ ялгах урвалж, оношлуур, хувийн хамгаалах хэрэгсэл болон бусад хэрэгслийн санхүүжилт авсан эрүүл мэндийн байгууллагад сорьц цуглуулахад 2262 төгрөг, шинжилгээ хийхэд 4755 төгрөгөөр өртгийг тооцож санхүүжилтийг олгоно.

1.7. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас Урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал /УТ-ПГУ/ шинжилгээг дөрвөөр багцалж санхүүжүүлнэ.

Хоёр. Даатгуулагчид тавигдах шаардлага

- 2.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн байх;
- 2.2. Эмчийн заалтаар хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авахаар ирсэн байх;
- 2.3. Энэхүү журмын 1.5-д заасан эмчийн заалтаар коронавируст халдварт (КОВИД-19)-ын шинжилгээнд хамрагдахаар сонгогдсон байх;

Гурав. Эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага

- 3.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээтэй байх;

3.2. Тухайн эмнэлэг коронавируст халдвар (КОВИД-19)-ын полимеразын гинжин урвал /ПГУ/ шинжилгээг хийх лабораторитой байх эсвэл чадамж бүхий лабораторитой гэрээ байгуулсан байх;

3.3. Шинжилгээ өгсөн даатгуулагчийн мэдээллийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын нэгдсэн мэдээллийн санд холбох техникийн шаардлагыг хангаж, шинжилгээний хариуг цахимаар 48 цагийн дотор илгээх боломжийг бурдуулсэн байх;

3.4. Сорьц цуглуулах, шинжилгээ хийхэд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаалыг баримтлан ажиллах;

3.5. Сорьцыг тээвэрлэхдээ Эрүүл мэндийн болон Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан тушаалыг мөрдөх;

Дөрөв. Шинжилгээ хийх лабораторит тавигдах шаардлага

4.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээтэй байх;

4.2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх полимеразын гинжин урвал /ПГУ/ шинжилгээ хийх лабораторит тавигдах ерөнхий шаардлагыг хангасан байх;

4.3. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн вирус судлалын лавлагаа лабораториос батламж авсан, чанарын хяналтад тогтоосон журмын дагуу хамрагддаг байх;

4.4. Шинжилгээний хариуг 24 цагийн дотор гарган цахимаар хариуг илгээх боломжийг бурдуулсэн байх;

Тав. Даатгуулагчийг шинжилгээнд хамруулан, тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

5.1. Хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээ авах үед:

5.1.1. Эмчийн заалтаар хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээ авахаар ирж буй даатгуулагчийн полимеразын гинжин урвал /ПГУ/-ын шинжилгээний хариу 72 цагийн хугацаанд хүчинтэй байна.

5.1.2. Шинжилгээний хариу зерэг гарч баталгаажсан үед Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаалын дагуу арга хэмжээг авна.

5.1.3. Шинжилгээний хариу сөрөг тохиолдолд хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

5.2. Тархвар судлалын заалтаар шинжилгээнд хамрагдах үед:

5.2.1. Сэжигтэй тохиолдол, түүний ойрын, дам хавьталд тархвар судлаач эмчийн шийдвэрээр Коронавируст халдвар /КОВИД-19/-ын шинжилгээнд хамрагдахаар сонгогдсон байна.

5.2.2. Шинжилгээний хариу зерэг гарч баталгаажсан үед Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаалын дагуу арга хэмжээг авна.

5.2.3. Шинжилгээний хариу сөрөг тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хяналтыг үргэлжлүүлнэ.